ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/142/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ ....... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....... 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....... 9
3. Аудитын тайлан ....... 10
3.1 Ерөнхий зүйл ....... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 10
3.4 Материаллаг байдал ....... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....... 12
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 13
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....... 13
3.7.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ....... 13
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 13
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 13
4. Аудитын илрүүлэлт ....... 14
4.1. Залруулсан алдаа ....... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....... 14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 14
6. Аудитын тайлангийн хавсралт ....... 15
6.1. Албан шаардлага 2022.03.04 №46 /А2370452/ ХЭА-2022/142/НА-СТА-ТШЗ ....... 15

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗАА | Захирагчийн ажлын алба |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.04 № 86

танай ______ -ны № ______ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ТАХИЛГАТ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
А.УУГАНБААТАР ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

023030113

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,612,850.00** | **7,913,600.00** |
| **33** | **АВЛАГА** | 390,000.00 | 890,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 390,000.00 | 890,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 390,000.00 | 890,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 4,222,850.00 | 7,023,600.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 4,222,850.00 | 7,023,600.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 629,600.00 | 532,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,152,000.00 | 6,190,900.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 441,250.00 | 300,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **763,967,404.49** | **737,899,036.47** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 763,967,404.49 | 737,899,036.47 |
| **392** | **Биет хөрөнгө** | 595,787,404.49 | 569,719,036.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 660,037,451.96 | 675,037,451.96 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (100,796,696.58) | (131,628,066.03) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 25,380,000.00 | 8,680,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (23,378,888.05) | (8,469,999.79) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 50,497,216.60 | 53,047,116.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,912,203.76) | (28,633,225.42) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,868,484.00 | 2,808,484.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (1,377,959.68) | (1,592,724.85) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 470,000.00 | 470,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 168,180,000.00 | 168,180,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 168,180,000.00 | 168,180,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **768,580,254.49** | **745,812,636.47** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,200.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,200.00 | - |
| **413** | **Өглөг** | 3,200.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 3,200.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 3,200.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **768,577,054.49** | **745,812,636.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 768,577,054.49 | 745,812,636.47 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 263,499,828.00 | 263,499,828.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 263,499,828.00 | 263,499,828.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 48,366,317.71 | 25,601,899.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 48,366,317.71 | 48,366,317.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (22,764,418.02) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 456,710,908.78 | 456,710,908.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **768,580,254.49** | **745,812,636.47** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэ | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **171,199,444.60** | **155,999,805.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **34,822,044.60** | **16,800,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 34,822,044.60 | 16,800,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 34,822,044.60 | 16,800,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 34,822,044.60 | 16,800,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **136,377,400.00** | **139,199,805.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,065,000.00 | 980,605.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 765,000.00 | 980,605.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 135,312,400.00 | 138,219,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 135,312,400.00 | 138,219,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **165,798,151.61** | **178,764,223.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **165,798,151.61** | **178,764,223.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **153,258,614.67** | **175,904,198.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **76,909,940.25** | **78,850,211.39** |
| 210101 | Үндсэн цалин | 43,597,159.08 | 59,869,995.43 |
| 210102 | Нэмэгдэл | 17,750,305.19 | 13,936,313.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 745,650.47 | 2,357,700.44 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 14,816,825.51 | 2,686,202.12 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **10,706,108.89** | **11,146,423.64** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,632,688.04 | 7,904,899.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 768,354.21 | 832,099.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 614,681.97 | 665,699.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 285,515.24 | 166,399.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | **1,404,869.43** | **1,577,324.86** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,080,223.92 | 12,225,841.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,241,123.92 | 3,365,741.23 |
| 210302 | Түлш, халаалт | 6,529,100.00 | 8,710,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 310,000.00 | 150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,281,525.00** | **14,851,300.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,348,050.00 | 2,269,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,478,475.00 | 10,586,050.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,047,000.00 | 797,350.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 253,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 408,000.00 | 945,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **82,000.00** | **8,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 82,000.00 | 8,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,916,530.00** | **8,068,900.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 963,000.00 | 1,032,000.00 |
| 210602 | Тавилга | - | 20,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,953,530.00 | 7,016,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **618,000.00** | **882,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 618,000.00 | 882,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **820,150.00** | **2,249,354.50** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 265,500.00 | 1,620,604.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,350.00 | 219,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 112,300.00 | 52,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 33,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **38,844,136.61** | **47,622,168.02** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,933,000.00 | 3,063,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 36,911,136.61 | 44,558,268.02 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,539,536.94** | **2,860,024.24** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,730,000.00** | **1,830,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,730,000.00 | 1,830,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **9,809,536.94** | **-** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,809,536.94 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **1,030,024.24** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,030,023.74 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 0.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **5,401,292.99** | **(22,764,418.02)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 900,000.00 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 900,000.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (900,000.00) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **4,501,292.99** | **(22,764,418.02)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,499,828.00** | **456,710,908.78** | **43,865,024.72** | | **764,075,761.50** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **263,499,828.00** | **456,710,908.78** | **43,865,024.72** | | **764,075,761.50** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 4,501,292.99 | | **4,501,292.99** |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,499,828.00** | **456,710,908.78** | **48,366,317.71** | - | **768,577,054.49** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **263,499,828.00** | **456,710,908.78** | **48,366,317.71** | - | **768,577,054.49** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **263,499,828.00** | **456,710,908.78** | **48,366,317.71** | - | **768,577,054.49** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (22,764,418.02) | | **(22,764,418.02)** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,499,828.00** | **456,710,908.78** | **25,601,899.69** | - | **745,812,636.47** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **136,377,400.00** | **139,199,805.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **136,377,400.00** | **139,199,805.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,065,000.00 | 980,605.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 765,000.00 | 980,605.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 135,312,400.00 | 138,219,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 135,312,400.00 | 138,219,200.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **130,877,400.00** | **135,709,905.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **130,877,400.00** | **135,709,905.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **118,447,863.06** | **132,649,880.76** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 76,909,940.25 | 78,850,211.39 |
| 210101 | Үндсэн цалин | 43,597,159.08 | 59,869,995.43 |
| 210102 | Нэмэгдэл | 17,750,305.19 | 13,936,313.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 745,650.47 | 2,357,700.44 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 14,816,825.51 | 2,686,202.12 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,706,108.89 | 11,146,423.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,632,688.04 | 7,904,899.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 768,354.21 | 832,099.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 614,681.97 | 665,699.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 285,515.24 | 166,399.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,404,869.43 | 1,577,324.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,328,523.92 | 11,899,341.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,489,423.92 | 3,039,241.23 |
| 210302 | Түлш, халаалт | 6,529,100.00 | 8,710,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 310,000.00 | 150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,710,960.00 | 13,330,350.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,493,200.00 | 1,581,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,742,060.00 | 10,444,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 940,000.00 | 922,350.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000.00 | 103,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 335,700.00 | 279,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 200,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,090,180.00 | 10,085,760.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,504,860.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,090,180.00 | 8,580,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 632,500.00 | 882,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 632,500.00 | 882,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,069,650.00 | 2,259,354.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 515,000.00 | 230,604.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,350.00 | 219,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 108,500.00 | 52,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 3,800.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,000,000.00 | 3,996,440.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 3,996,440.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,429,536.94** | **3,060,024.24** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,620,000.00 | 2,030,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,620,000.00 | 2,030,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,809,536.94 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,809,536.94 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 1,030,024.24 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,030,023.74 |
| 213405 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | | 0.50 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,500,000.00** | **3,489,900.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,500,000.00** | **3,489,900.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,500,000.00** | **3,489,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,500,000.00 | 3,489,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 5,500,000.00 | 3,489,900.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(5,500,000.00)** | **(3,489,900.00)** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Тайлант хугацаа:2021.12.31** **/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **138,219,200.00** | **137,189,176.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **138,219,200.00** | **137,189,176.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **136,189,200.00** | **135,159,176.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **79,379,700.00** | **78,850,211.39** |
| 210101 | Үндсэн цалин | 51,381,800.00 | 59,869,995.43 |
| 210102 | Нэмэгдэл | 17,184,500.00 | 13,936,313.40 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 10,813,400.00 | 2,686,202.12 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **11,233,300.00** | **11,146,423.64** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,904,900.00 | 7,904,899.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 832,100.00 | 832,099.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 665,700.00 | 665,699.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 166,400.00 | 166,399.89 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,664,200.00 | 1,577,324.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **11,900,000.00** | **11,899,341.23** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,300,000.00 | 3,039,241.23 |
| 210302 | Түлш, халаалт | 8,300,000.00 | 8,710,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,603,300.00** | **12,580,350.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,450,000.00 | 1,381,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,900,000.00 | 9,894,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 940,000.00 | 922,350.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 33,600.00 | 103,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 279,700.00 | 279,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **201,900.00** | **200,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 201,900.00 | 200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **13,590,300.00** | **13,575,660.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000,000.00 | 4,994,760.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,590,300.00 | 8,580,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,000,000.00** | **882,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 882,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,280,700.00** | **2,028,750.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 239,000.00 | 219,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 254,800.00 | 52,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 62,900.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,400,000.00 | 1,400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,000,000.00** | **3,996,440.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,000,000.00 | 3,996,440.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,030,000.00** | **2,030,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,030,000.00** | **2,030,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,030,000.00 | 2,030,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **138,219,200.00** | **137,189,176.26** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **138,219,200.00** | **137,189,176.26** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 138,219,200.00 | 137,189,176.26 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **980,605.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **980,605.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **980,605.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **750,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 550,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **230,604.50** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 230,604.50 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.50** |
| 213405 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 0.50 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **980,605.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **980,605.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 980,605.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны эрхэм зорилго нь "Иргэдийн оролцоонд тулгуурлан төрийн үйлчилгээг ил тод, шударга, хөнгөн шуурхай нээлттэй хүргэж, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх, чадварлаг, үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх" гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 165.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 0.4 | 0.9 | 0.5 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 4.2 | 7.0 | 2.8 |
| Үндсэн хөрөнгө | 764.0 | 737.9 | (26.1) |
| **Нийт хөрөнгө** | **768.6** | **745.8** | (22.8) |
| Өр төлбөр | 0.0 | - | (0.0) |
| Засгийн газрын оролцоо | 768.6 | 745.8 | (22.8) |
| Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/ | 263.5 | 263.5 | - |
| Өмнөх үеийн үр дүн | 48.4 | 48.4 | - |
| Тайлант үеийн үр дүн | - | (22.8) | (22.8) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 456.7 | 456.7 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **768.6** | **745.8** | (22.8) |

Авлага дансанд байгууллагаас авах 0.4 сая, зураг, төсвийн үнэ зардалд бичсэнийг авлага үүсгэсэн 0.5 сая, нийт 0.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7.0 сая болж 2.8 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө данс худалдаж авсан 3.5 сая, үнэ төлбөргүй хүлээн 15.0 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталж данснаас хасагдсан тээврийн хэрэгслийн 16.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 745.8 сая болж 22.8 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 15.2 сая төгрөгөөр буюу 8.9 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 13.0 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамж, эд хогшил, урсгал засварын зардал байна

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 161.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 23.5 сая төгрөгөөр бууруулж 138.2 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 138.2 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 138.2 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 137.2 сая төгрөгийг зарцуулж 1.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 0.2 сая, хангамж, бараа материалын зардалд 0.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 133.0 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлэхээс 10.0 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

Өгсөн зөвлөмж : Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### 3.7.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсөв захирагчдад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасан.

Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын алба нь батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 0.9 сая төгрөгийн тавилга авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

### 3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.1. Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Барилгын засварын зураг, төсвийн урьдчилгааг зардалд бичсэнийг авлага үүсгэж залруулав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Тахилгат тосгоны ЗАА | 1 | 0.5 | 1 | 0.5 | | | | | | |
| Дүн | | 1 | 0.5 | 1 | 0.5 | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Тахилгат тосгоны ЗАА | 2 | 10.9 | | | | | 1 | 0.9 | 1 | 10.0 |
| Дүн | | 2 | 10.9 | | | | | 1 | 0.9 | 1 | 10.0 |
| Нийт дүн | | 3 | 11.4 | 1 | 0.5 | | | 1 | 0.9 | 1 | 10.0 |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 03 дугаар сарын 04 Дугаар 46/А2370452 Чингис хот
ХЭА-2022/142/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 940.0 мянган төгрөгийн тавилга худалдаж авсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дунд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.4.-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д **“**хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал**”** заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тахилгат тосгоны захирагч А.Ууганбаатар, нягтлан бодогч Н.Батсайхан нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

Аудитор Б.Хуланхатан

Аудитын менежер Д.Оюунтуяа

2317144297

023040181

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199